



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/372

Булган сум

Г Аймаг, сумын баяр наадмын хугацааг
тогтоох тухай Г

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Нийтээр тэмдэглэх болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын 104 жилийн ойн Булган аймгийн баяр наадам болон Хялганат тосгон, Баян-Агт сум, Булган сумаас бусад сумын наадмыг 2025 оны 07 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гарган, Үндэсний их баяр наадам угтсан тохижилт, бүтээн байгуулалт, соёлжилтыг дээшлүүлэхэд чиглүүлж ажиллахыг аймгийн баяр наадмыг зохион байгуулах хороо, сумын Засаг дарга, албан байгууллага аж ахуй, нэгжийн дарга удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

